



БАТЛАВ  
ЭМГЭГ СУДЛАЛЫН  
МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ЕРӨНХИЙ МЭРГЭЖИЛТЭН

*Э.Баярмаа*  
Э.БАЯРМАА

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн  
2020 оны 08 сарын 11 ний өдрийн  
12 дугаар тогтоолын хавсралт

## АНАТОМИЙН ЭМГЭГ СУДЛАЛЫН ЛАБОРАТОРИЙН ТЕХНИКЧ

**АХЛАХ** зэрэг горилогч анатомийн эмгэг судлалын лабораторийн техникч нь дараах тусгай шаардлагыг хангасан байна .Үүнд

1. Мэргэжлээрээ тасралтгүй 8-оос цөөнгүй жил ажилласан байх
2. Сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/мэргэжлийн чиглэлийн багц сургалтанд хамрагдсан байна(сертификатаар баталгаажуулна).
3. Тусгай будгийн аргыг бие дааж гардан хийх чадвар эзэмшсэн байх ( 3 -аас цөөнгүй тусгай будаг)
4. Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож 2-оос цөөнгүй илтгэл,бүтээлийг хэлэлцүүлсэн, мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн байна.(Өөрөө болон бусад бусад эмгэг судлаач эмч, лабораторийн техникч нартай хамтарсан байх)
5. Лабораторийн орчин үеийн автомат аппаратыг ажиллуулах, ашиглах мэдлэг, чадвар бүрэн эзэмшсэн байх
6. Мэргэжлээрээ ажилласан сүүлийн 5 жилийн ажлын дэлгэрэнгүй тайланг бичиж өгөх.

**ТЭРГҮҮЛЭХ** зэрэг горилогч анатомийн эмгэг судлалын лабораторийн техникч нь дараах тусгай шаардлагыг хангасан байна .Үүнд

1. Ахлах зэрэг хамгаалснаас хойш 5 жил тасралтгүй ажилласан байх
2. Сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан/мэргэжлийн нийгэмлэг холбоо/мэргэжлийн чиглэлийн багц сургалтанд хамрагдсан байна.
3. Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож 3 өөс цөөнгүй илтгэл, бүтээлийг хэлэлцүүлсэн,мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн байна.(Өөрөө олон бусад бусад эмгэг судлаач эмч, лабораторийн техникч нартай хамтарсан байх)

4. Эмгэг судлалын лабораторийн орчин үеийн шинэ технологи нэвтрүүлсэн эсвэл багт орж ажиллаж, тусгай будгийн аргыг бие дааж гардан хийх чадвар эзэмшсэн байх (5-аас цөөнгүй тусгай будаг )
5. Залуу лабораторийн техникчдийг дагалдуулан сургах, мэргэжил, арга зүйгээр хангах чадвар эзэмшсэн байх
6. Иммуногистохимийн шинжилгээний арга, хөлдөөсөн зүсмэг хийх ур чадвар эзэмшсэн байх
7. Эмгэг судлалын анагаах ухааны оношлогооны шинэ, шинэлэг арга, технологиос эмгэг судлалын практикт нэвтрүүлэх, лабораторийн тоног төхөөрөмжийн баримт, бичиг боловсруулах чадвартай (заавар, удирдамж, стандарт зэрэг мэргэжлийн бичиг баримт боловсруулах багийн ажлын хэсэгт хамтран ажиллаж болно)
8. Мэргэжлээрээ ажилласан сүүлийн 5 жилийн ажлын дэлгэрэнгүй тайланг бичиж өгөх.
9. Бакалаврын дипломтой бол давуу тал болно.